

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2022.07.21

№ 22/63

Улаанбаатар хот

Ногдол ашиг хувиарлах тухай

Компанийн тухай хуулийн 46, 76 дугаар зүйлийн 76.1.12 дэх заалт, 80 дугаар зүйлийн холбогдох заалтууд, Банкны тухай хуулийн 29, 35 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хурлыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Богд Банк” ХК нь 2022 оны 2 дугаар улирлын татварын дараах цэвэр ашиг болох 8,033,500,938.79 төгрөгний 15% болох 1,205,025,140.82 төгрөгний ногдол ашгийг нийт эргэлтэнд байгаа 62,500,000.00 ширхэг хувьцаанд ногдуулан мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дунг 19.28 төгрөг байхаар тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөр тогтоож, эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор ногдол ашгийг хуваарилсугай.
4. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тус тогтоолын 3 дугаар зүйлд заасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлон мэдэгдэж байгааг дурьдсугай.
5. Тус тогтоолыг хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл болон Хөрөнгийн биржийн сайтаар 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн дотор мэдэгдсүгэй.
6. Ногдол ашгийг дээрх хэлбэрээр олгож Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлаар танилцуулж тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-т даалгасугай.
7. Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохицтой харьцааны үзүүлэлтийг хангасан болохыг дурьдсугай.
8. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах болохыг дурьдсугай.
9. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэх болохыг дурьдсугай.
10. Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.

11. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
12. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлон Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ